

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
УИХ	Улсын их хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.03.25 № 01/993
танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.АРИУНБОЛД
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Боловсролын зээлийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Боловсролын зээлийн сангийн 2020 оны бодлогын баримт бичигт төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 15 зорилт, 15 арга хэмжээг хэрэгжүүлэн ТЕЗ-д гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлүүлэхээр хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсөв захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	219,965,218,107.99	267,156,453,181.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	105,036,790.75	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	105,036,790.75	-
3122	Гадаад валют	105,036,790.75	-
31222	Монгол банк дахь харилцах	105,036,790.75	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,023,644,769.39	848,670,810.21
321	Үнэт цаас	1,023,644,769.39	848,670,810.21
32110	Төгрөг	1,023,644,769.39	848,670,810.21
33	АВЛАГА	218,835,194,147.85	266,306,958,421.02
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	55,000.00
33400	Зээлийн хүүгийн авлага	-	1,324,083.56
335	Бусад авлага	1,117,416.85	30,752,233.85
3351	Байгууллагаас авах авлага	1,117,416.85	30,752,233.85
336	Зээлийн авлага	218,834,076,731.00	266,274,827,103.61
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	218,834,076,731.00	266,274,827,103.61
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	218,834,076,731.00	266,274,827,103.61
35	БАРАА МАТЕРИАЛ	1,342,400.00	823,950.00
354	Хангамжийн материал	1,342,400.00	823,950.00
35410	Бичиг хэргийн материал	1,342,400.00	823,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	154,324,431.14	220,984,000.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	154,324,431.14	220,984,000.40
392	Биет хөрөнгө	31,306,837.80	62,439,093.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,800,000.00	49,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,800,000.00)	(49,800,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	99,014,361.50	145,878,306.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,788,414.41)	(102,103,902.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,357,295.86	54,072,295.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,276,405.15)	(35,407,606.05)
393	Биет бус хөрөнгө	123,017,593.34	158,544,906.67
39301	Програм хангамж	140,320,200.00	193,480,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(17,302,606.66)	(34,935,293.33)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	220,119,542,539.13	267,377,437,181.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,075,294.86	1,116,153.73
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,075,294.86	1,116,153.73
413	Өглөг	14,075,294.86	1,116,153.73
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,092,366.86	473,608.82
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	587,544.91
4136	Бусад өглөг	8,982,928.00	55,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	8,982,928.00	55,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	220,105,467,244.27	267,376,321,027.90
51	Засгийн газрын хувь оролцоо	220,105,467,244.27	267,376,321,027.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	29,809,531.00	29,809,531.00
51101	Өмч: - төрийн	29,809,531.00	29,809,531.00
512	Хуримтлагдсан үр дүн	220,075,657,713.27	267,346,511,496.90
51210	Өмнөх үеийн үр дүн	220,075,657,713.27	248,167,578,151.47
51220	Тайлант үеийн үр дүн	-	19,178,933,345.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	220,119,542,539.13	267,377,437,181.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	69,711,990,200.36	21,336,679,547.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,894,599.06	196,487,697.71
120	Нийтлэг татварын бус орлого	7,894,599.06	196,487,697.71
120002	Хүүгийн орлого	-	18,445,521.70
120002	Хүүгийн орлого	-	18,445,521.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	178,042,176.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	128,403,411.01
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	49,638,765.00
120009	Бусад орлого	7,894,599.06	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	69,704,095,601.30	21,140,191,849.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	69,681,399,477.98	21,140,191,849.48
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	69,681,399,477.98	21,140,191,849.48
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,696,123.32	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,696,123.32	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	26,754,777,366.15	10,366,206,972.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,754,777,366.15	10,366,206,972.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	447,470,021.63	493,705,106.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,121,116.05	328,737,582.83
210101	Үндсэн цалин	251,121,116.05	328,737,582.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,280,008.65	43,282,282.06
210201	Тэтгэврийн даатгал	23,282,043.09	29,957,411.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,543,855.09	3,524,401.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,032,168.37	2,661,601.07
210204	Ажилгүйдлийн даатгал	492,903.92	648,988.08
210205	Эрүүл мэндийн даатгал	4,929,038.18	6,489,880.50
2104	Хангамж, бараа материалын зардал	23,226,938.53	18,848,892.52
210401	Бичиг хэрэг	9,723,920.00	7,053,850.00
210402	Тээвэр, шатахуун	3,616,124.00	3,469,925.55
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,933,394.53	6,136,186.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,953,500.00	2,188,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,242,070.00	-
210604	Урсгал засвар	24,242,070.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,336,300.00	2,280,929.00
210702	Дотоод албан томилолт	2,336,300.00	2,280,929.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,378,990.00	9,189,143.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,991,990.00	5,974,143.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,387,000.00	3,215,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,884,598.40	91,366,276.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	55,286,900.85
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,884,598.40	36,079,375.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,307,307,344.52	9,872,501,866.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,322,309,786.90	6,910,553,847.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,321,311,626.90	6,884,594,547.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	998,160.00	25,549,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,984,997,557.62	750,957,348.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,925,772,672.36	732,144,177.66

213305	Нэмэлт санхүүжилтийн шилжүүлэг	59,224,885.26	18,813,171.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	42,957,212,834.21	13,181,463,245.01
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	73,996,267.90	8,208,460,770.62
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	73,996,267.90	8,208,460,770.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33,917,495.21	2,210,990,670.20-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	33,917,495.21	
230001	Эргэж төлөгдөх цэвэр зээл		2,210,990,670.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	40,078,772.69	8,208,460,770.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	42,997,291,606.90	19,178,933,345.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>73,279,509,204.26</u>	<u>23,520,493,280.76</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,519,501,441.56	150,497,589.76
120	Нийтлэг татварын бус орлого	3,519,501,441.56	150,497,589.76
120002	Хүүгийн орлого	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,512,913,107.77	150,497,589.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,512,913,107.77	99,010,688.91
120009	Бусад орлого	6,588,333.79	51,486,900.85
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	69,760,007,762.70	23,369,995,691.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	69,681,399,477.98	23,351,182,519.68
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	69,681,399,477.98	21,140,191,849.48
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	2,210,990,670.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,608,284.72	18,813,171.32
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	78,608,284.72	18,813,171.32
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>26,729,034,719.14</u>	<u>8,148,308,111.50</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,729,034,719.14	8,148,308,111.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,727,374.20	486,741,915.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,337,005.62	325,753,724.75
210101	Үндсэн цалин	175,137,241.37	219,165,171.88
210102	Нэмэгдэл	46,338,973.97	79,816,772.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,860,790.28	26,771,780.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,281,194.05	50,130,945.66
210201	Тэтгэврийн даатгал	20,626,000.00	37,490,122.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,056,294.05	3,174,213.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,493,100.00	2,379,629.13
210204	Ажилгүйдлийн даатгал	373,500.00	594,907.30
210205	Эрүүл мэндийн даатгал	3,732,300.00	6,492,072.88
2104	Хангамж, бараа материалын зардал	21,151,814.53	17,155,272.06
210401	Бичиг хэрэг	7,376,420.00	6,069,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,888,500.00	2,882,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,933,394.53	6,014,642.06
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,953,500.00	2,188,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,242,070.00	-
210604	Урсгал засвар	24,242,070.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,336,300.00	2,280,929.00
210702	Дотоод албан томилолт	2,336,300.00	2,280,929.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,378,990.00	39,934,143.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,991,990.00	5,974,143.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,387,000.00	33,960,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	51,486,900.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	51,486,900.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,307,307,344.94	7,661,566,196.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,322,309,786.90	6,910,553,847.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,321,311,626.90	6,884,594,547.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25,549,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	998,160.00	410,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,984,997,558.04	751,012,348.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,925,772,672.78	732,199,177.66
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	59,224,885.26	18,813,171.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	46,550,474,485.12	15,372,185,169.26
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	8,160,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,160,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	8,160,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	8,160,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(8,160,000.00)
14	Бусад эх үүсвэр	73,996,267.90	6,000,160.78
145001	Гадаад валютын ханшийн зөрүү	73,996,267.90	6,000,160.78
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	47,047,464,194.29	15,475,062,120.78
230001	Эргэж төлөгдөх зээл /тайлант онд олгосон зээл/	47,047,464,194.29	13,264,071,450.58
230001	Эргэж төлөгдөх зээл /цэвэр зээл/		2,210,990,670.20
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	33,917,495.21	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	33,917,495.21	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(47,007,385,421.60)	(15,469,061,960.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(456,910,936.48)	(105,036,790.75)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	561,947,727.23	105,036,790.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	105,036,790.75	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	185,135,306,223.38	185,165,115,754.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	(8,056,940,117.01)	(8,056,940,117.01)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	177,078,366,106.37	177,108,175,637.37
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	42,997,291,606.90	42,997,291,606.90
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	220,075,657,713.27	220,105,467,244.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	28,091,920,438.20	28,091,920,438.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	248,167,578,151.47	248,197,387,682.47
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	19,178,933,345.43	19,178,933,345.43
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	267,346,511,496.90	267,376,321,027.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,012,287,600.00	18,407,049,642.06	18,605,237,957.94	49.7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,012,287,600.00	20,618,040,312.26	21,394,247,287.74	49.1
УРСГАЛ ЗАРДАЛ	16,018,912,800.00	7,353,968,861.68	8,664,943,938.32	45.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	443,936,900.00	443,415,014.48	521,885.52	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,776,500.00	325,753,724.75	22,775.25	100.0
Үндсэн цалин	219,461,900.00	219,165,171.88	296,728.12	99.9
Нэмэгдэл	80,481,000.00	79,816,772.79	664,227.21	99.2
Унаа хоолны хөнгөлөлт	25,833,600.00	26,771,780.08	(938,180.08)	103.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,579,900.00	50,130,945.66	448,954.34	99.1
Тэтгэврийн даатгал	37,548,700.00	37,490,122.42	58,577.58	99.8
Тэтгэмжийн даатгал	3,257,800.00	3,174,213.93	83,586.07	97.4
ҮОМШӨ-ний даатгал	2,606,300.00	2,379,629.13	226,670.87	91.3
Ажилгүйдлийн даатгал	651,500.00	594,907.30	56,592.70	91.3
Эрүүл мэндийн даатгал	6,515,600.00	6,492,072.88	23,527.12	99.6
Хангамж, бараа материалын зардал	17,171,300.00	17,155,272.06	16,027.94	99.9
Бичиг хэрэг	6,085,000.00	6,069,400.00	15,600.00	99.7
Тээвэр, шатахуун	2,882,300.00	2,882,300.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,014,700.00	6,014,642.06	57.94	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,189,300.00	2,188,930.00	370.00	100.0
Томилолт, зочны зардал	2,281,000.00	2,280,929.00	71.00	100.0
Дотоод албан томилолт	2,281,000.00	2,280,929.00	71.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,128,200.00	48,094,143.00	34,057.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,007,300.00	5,974,143.00	33,157.00	99.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,120,900.00	42,120,000.00	900.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,574,975,900.00	6,910,553,847.20	8,664,422,052.80	44.4
Бусад урсгал шилжүүлэг	15,574,975,900.00	6,910,553,847.20	8,664,422,052.80	44.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,549,016,600.00	6,884,594,547.20	8,664,422,052.80	44.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,549,300.00	25,549,300.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	-	100.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	25,993,374,800.00	13,264,071,450.58	12,729,303,349.42	51.0
Эргэж төлөгдөх зээл	25,993,374,800.00	13,264,071,450.58	12,729,303,349.42	51.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37,012,287,600.00	18,407,049,642.06	18,605,237,957.94	49.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,012,287,600.00	20,617,578,623.07	21,394,708,976.93	49.1
Улсын төсвөөс санхүүжих	42,012,287,600.00	20,617,578,623.07	21,394,708,976.93	49.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	461,689.20	(461,689.20)	
Туслах үйл ажиллагааны	-	461,689.20	(461,689.20)	

орлогоос санхүүжих				
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(5,000,000,000.00)	(2,210,990,670.20)	(2,789,009,329.80)	44.2
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(5,000,000,000.00)	(2,210,990,670.20)	(2,789,009,329.80)	44.2
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
Төсвийн байгууллага	1	1	-	100
АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	-	100
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	22	22	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	18,813,171.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	18,813,171.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	18,813,171.32
213305	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		18,813,171.32
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	18,813,171.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	18,813,171.32
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	18,813,171.32
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүгнэлтэд үндэслэн шалгагдагч этгээдэд ашиглагдахгүй хөрөнгийг данснаас хасах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлүүлэх, худалдан авалтын төлбөрийн цахим баримтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын аудитын хоёрдугаар газрын менежер С.Нацагдорж анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор Ч.Дашдаваа, Н.Нямсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсролын зээлийн сан 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 120 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Боловсролын зээлийн сангийн зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулахад орших бөгөөд сангийн хөрөнгийг бүрдүүлэх, уг хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, тайлагнах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. Боловсролын зээлийн сангийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд:

- Оюутны хөгжлийн зээл
- Гадаад зээл
- Хөнгөлөлттэй зээл
- Буцалтгүй тусламж
- Тэтгэлэг

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Нэмэгдсэн болон өөрчлөлт орсон, хууль, тогтоол, журмууд: Үүнд:

- Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- ЗГ-ын Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай 70 дугаар тогтоол;
- ЗГ-ын Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах журам батлах тухай 2013 оны 271 дүгээр тогтоол;

- ЗГ-ын Боловсролын зээлийн сан байгуулах талаар авах арга хэмжээний тухай 2016 оны 111 дүгээр тогтоол;
- ЗГ-ын Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам батлах тухай 2018 оны 46 дугаар тогтоол;
- ЗГ-ын Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам батлах тухай 2014 оны 71 дугаар тогтоол;
- Сангийн сайдын Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам батлах тухай 74 дүгээр тушаал;

Мөн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас дараах ЗГ-ын тогтоолууд гарсан байна. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай 187;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 78 ;
- Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 114;
- Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай 168;
- Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний 183 дугаар тогтоолууд.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Боловсролын зээлийн сан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь БШУС-ын 2017 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байсан.

Тайлант онд БЗС-ийн санхүүгийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан захирлын 2020 оны А/88 дүгээр тушаалаар баталгаажуулан санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Боловсролын зээлийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 69,756.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 697.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг аудитын хугацаанд залруулсан 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 29,545.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 295.4 сая төгрөгөөр дахин тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Боловсролын зээлийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 47,257.9 сая төгрөгөөр буюу 21.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт-1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	105.0	-	(105.0)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,023.6	848.7	(174.9)
Авлага	218,835.2	266,307.0	47,471.8
Бараа материал	1.3	0.8	(0.5)
Үндсэн хөрөнгө	154.3	221.0	66.7
Нийт хөрөнгө	220,119.5	267,377.4	47,257.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР	14.1	1.1	(13.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	220,105.5	267,376.3	47,270.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	220,119.5	267,377.4	47,257.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 105.0 сая төгрөгөөр буурсан нь Монгол банканд бүртгэлтэй орлого төвлөрүүлдэг дансны оны эхний үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 848.7 сая төгрөг болж, 174.9 сая төгрөгөөр буурсан нь 2016-2017 онуудад арилжааны банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийг богино хугацаат хөрөнгө оруулалтаар бүртгэсэн ба тайлант онд банкаар дамжуулан олгосон зээлийн эргэн төлөлтөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 266,307.0 сая төгрөг болж 47,471.8 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оноос оюутны хөгжлийн зээлийн авлага 4,779.1 сая төгрөг, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад олгосон зээлийн авлага 45,934.1 сая төгрөгөөр нэмэгдэж, хөнгөлөлттэй зээлийн авлага 3,272.4 сая төгрөгөөр буурснаас тус тус голлон шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 221.0 сая төгрөг болж 66.7 сая төгрөгөөр өссөн нь данс бүртгэлд тусгаагүй байсан 45.0 сая төгрөгийн гадаад зээлийн программыг нэмж бүртгэсэн, урсгал төсвийн худалдан авалтаар 8.2 сая төгрөг, БШУЯ-аас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 49.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1.1 сая төгрөг болж 13.0 сая төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбоотой өглөг буурсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 267,376.3 сая төгрөг болж 47,270.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үр дүн 19,178.9 сая төгрөг, өмнөх онуудын гадаад зээлийн ханшийн тэгшитгэлийг нөхөн тооцсон, зээлээ төлсөн болон зээлээс чөлөөлөгдсөн суралцагчдын авлагыг данснаас хасаж залруулан бүртгэснээс өмнөх үеийн үр дүн 28,091.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 101,141.3 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 24,602.1 сая төгрөгөөр бууруулж 76,539.2 сая төгрөгөөр баталсан боловч тайлант онд 2 удаагийн тодотгол хийж тодотгосон төсвөөр 42,012.3 сая төгрөгөөр батлагдсан байна.

Тодотгосон төсвөөр нийт зардлыг 34,526.9 сая төгрөгөөр бууруулсан нь Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас 2020 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвөөс санхүүжих сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг, гадаад дотоод оюутны зээлийн санхүүжилтийг хасаж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 42,012.3 сая төгрөгийн төсөв баталснаас 42,012.3 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, төсөвт төвлөрүүлэх эргэж төлөгдөх цэвэр зээлийг 5,000.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 21,140.2 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 150.5 сая төгрөг, гадаад валютын ханшийн зөрүүгээс 6.0 сая төгрөг нийт 21,296.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 520.8 сая төгрөг, оюутны буцалтгүй тусламж, тэтгэлгийн санхүүжилтэд 6,884.6 сая төгрөг, гадаад дотоод оюутны зээлд 13,264.1 сая төгрөгийг санхүүжүүлж, өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон төсвийн дутуу зарцуулалт нийт 732.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөн тайлант оны эргэж төлөгдөх цэвэр зээлд 5,000.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,210.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	ХАХ код	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	71803	Дээд боловсрол (эргэж төлөгдөх цэвэр зээлийг хассан дүн)	37,012.3	18,407.1	(18,605.2)	49.7
	71803	Дээд боловсрол	42,012.3	20,618.0	(21,394.3)	49.7
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	443.9	443.4	(0.5)	99.9
2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	26.0	26.0	-	100
3	81812	Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг	710.9	610.5	(100.4)	85.9
4	81813	Зарим суралцагч (бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй)-дад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг	3,097.4	3,097.4	-	100
5	81828	Орон нутгаас суралцаж буй оюутнуудын замын зардлын хөнгөлөлт	218.7	-	(218.7)	-
6	81822	Гадаад суралцагсдын зардал	2,881.3	658.9	(2,222.4)	22.9
7	81828	Багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөр	2,282.6	1,484.2	(798.4)	65
8	81826	Орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг	438.7	408.5	(30.2)	93.1
9	81849	Сувилагч мэргэжлээр суралцагчдын тэтгэлэг	5,919.4	625.1	(5,294.3)	10.6
10	81811	Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох зээл	5,993.4	1,743.0	(4,250.4)	29.1
11	81838	Дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөр	10,000.0	5,057.8	(4,942.2)	50.6
12	81846	Оюутны сургалтын төлбөрийн зээл	10,000.0	6,463.3	(3,536.7)	64.6
13	81404	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(5,000.0)	(2,211.0)	(3,536.7)	44.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон оюутны хөгжлийн зээлийн хүүгийн орлого 18.8 сая төгрөгийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 101, мэдээллийн хугацаа болоогүй 3, хугацаа хоцроосон 47 мэдээлэл, 12.7 сая төгрөгийн 2 зарлагын гүйлгээг оруулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 51,016.0 сая төгрөгийн 14 зөрчилд өгсөн 4.8 сая төгрөгийн төлбөрийн актын биелэлт 100 хувь, 43,840.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлагын биелэлт 83.0 хувь, 7,171.2 сая төгрөгийн 8 зөвлөмжийн хэрэгжилт 98 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4.8	1	4.8	-	-	100
Албан шаардлага	5	43,840.0	4	41,655.0	1	2,185.0	84
Зөвлөмж	8	7,171.2	8	7,171.2	-	-	98
Нийт дүн	14	51,016.0	13	48,831.0	-1	2,185.0	94

Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн дундаж 94 хувьтай байгаа ба үүнээс гадаадад дээд боловсрол эзэмших суралцагчдад ЗГ-аас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжилд багтаагүй 14 суралцагчийг 2012-2015 онд суралцуулж 1,162.5 сая төгрөг, сонгон шалгаруулалтгүй 11 суралцагчдыг 2017-2018 онд гадаад зээлээр бакалаврын хөтөлбөрт суралцуулж 985.4 сая төгрөг нийт 2,185.0 сая төгрөгийн зөрчилд ТЕЗ-д албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,387.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,229.4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн 4 алдааг залруулж, 157.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 1 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 2,229.4 сая төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд худалдан авсан 1.3 сая төгрөгийн санхүүгийн программыг данс бүртгэлд тусгаагүй;
- Оюутны хөгжлийн зээлийн программын үлдэгдэл төлбөр 6.8 сая төгрөгөөр программын дансны үнийг нэмэгдүүлээгүй;
- Нэмэлт дансанд данс андуурч төвлөрүүлсэн оюутны зээлийн эргэн төлөлтийг 10.4 сая төгрөгийг үндсэн дансанд шилжүүлж бүртгээгүй;
- Гадаад, дотоод оюутан, хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт 2,210.9 сая төгрөгийг үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгээр тайлагнасан байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчлөөс шалгагдагч байгууллагад 1 албан шаардлага хүргүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчид 3 албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв. Үүнд:

1. Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно гэсэн боловч эргэн төлөх журам байхгүй, тодорхойгүйгээс зээлийн авлага олон жилээр хуримтлагдах, найдваргүй авлага болох эрсдэлтэй, санхүүгийн тайланд хэрэгжихээ зогсоосон хөнгөлөлттэй зээлийн олон жилийн насжилттай авлагын үлдэгдэл байна. Үүнд:
 - Дотоодын их дээд сургуульд хөнгөлөлттэй зээлээр 1995-2003 онд магистрын хөтөлбөрт суралцсан 95 төгсөгчийн 45.0 сая, 2004-2007 онд бакалаврын хөтөлбөрт суралцсан 3,128 төгсөгчийн 3,530.5 сая нийт 3,575.5 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй;
 - Мөн 2008-2020 онд хөнгөлөлттэй зээлээр бакалавр, магистрын хөтөлбөрт суралцсан 11,267 төгсөгчийн 13,168.6 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй ба тайлант онд 162.5 сая төгрөг, өмнөх онд 439.7 сая төгрөг эргэн төлөгдсөн боловч тус зээлийн эргэн төлөлт хангалтгүй.

Засгийн газрын Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай 2013 оны 271 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.4-д Сургалтын төлбөрийн зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох асуудлыг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зохицуулна гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТЕЗ-д албан шаардлага хүргүүлэх.

2. Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог батлаагүй, гадаад орны дээд боловсролын байгууллагын бакалавр магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа суралцагчдад олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээлийн хэмжээг тогтоогоогүй.

Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмын 1.5-д Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн оны 3 дугаар сард багтаан батална, 2020 оны Дээд боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай 70 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журмын 2.1-д Сургалтын төлбөрийн зээлийн хэмжээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, тухайн улсын

амьжиргааны түвшинтэй харьцуулсны үндсэн дээр Засгийн газар жил бүр ялгавартайгаар тогтооно гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТЕЗ-д албан шаардлага хүргүүлэх.

3. Өмнөх онуудад гадаадад дээд боловсрол эзэмших суралцагчдад сонгон шалгаруулалтгүй 11 суралцагчдыг 2017-2018 онд гадаад зээлээр бакалаврын хөтөлбөрт суралцуулж 985.4 сая төгрөг, ЗГ-аас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжилд багтаагүй 14 суралцагчийг 2012-2015 онд суралцуулж 1,162.5 сая төгрөг, нийт 2,185.0 сая төгрөгийг олгосон.

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7-д Гадаад улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа Монгол Улсын иргэнд Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл олгож болно;

Засгийн газрын 2013 оны Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай 271 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмын 1.3-д Дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Times Higher Education World University Rankings” (THE) болон “Academic Ranking of World Universities” (ARWU) жагсаалтад багтсан их сургуулийг дэлхийн шилдэг их сургуульд тооцно, мөн журмын 1.4-д Энэхүү журмын 1.3.-т заасан жагсаалтын эхний 20-д багтсан их сургуулийн суралцагч мэргэжлийн чиглэл харгалзахгүйгээр, 21-100-д багтсан их сургуульд Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжлээр суралцагч сургалтын зээлд хамрагдах хүсэлт гаргах эрхтэй гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТЕЗ-д албан шаардлага хүргүүлэх.

4. Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 101 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 47 мэдээлэл, 12.7 сая төгрөгийн зарлагын мэдээллийг оруулаагүй.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл Шилэн дансны зарчим 4.1.3-д тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл 6.1-д Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 157.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсан;

Өмнөх оны албан шаардлагаар өгсөн гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт зээлээр суралцаж төгссөн 79 суралцагч, магистр, докторын хөтөлбөрт 470 суралцагч БЗС-нд суралцаж төгссөн болон ажил эрхлэлтийн талаарх мэдээллээ бүртгүүлээгүй байгаа ба БЗС нь эдгээр суралцагчтай холбогдож бүртгэл хийх, бүртгэлийн программд зээл, зээлийн авлагыг оруулах ажлуудыг үе шаттайгаар хийж байгааг дараагийн аудитаар үргэлжлүүлэн үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Актлах саналтай ашиглагдахгүй байгаа 42 нэр төрлийн 39.4 сая төгрөгийн компьютер техник хэрэгслийг актлах шийдвэр гаргуулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах 70 нэр төрлийн 114.1 сая төгрөгийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх шаардлагатай байна.

1.2. Эрсдэл:

Хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө ихсэх, бүртгэлээр тавих хяналт сул байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 6.2.1-д элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, 7.1-д Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирлүүлж шийдвэрлэнэ.

Ашиглагдахгүй байгаа хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг ТӨБЗГ-т хандан шийдвэрлүүлэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

2.Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Тайлант онд 32 ААН-тэй хийсэн 61.4 сая төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 6 ААН-үүдээс 4.4 сая төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

2.2.Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт сул, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ их, хууль, журам мөрдөгдөхгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Боловсролын зээлийн сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит		Аудитын код: САГ-2021/10/СТА-ЗГТС	
2021		Боловсролын зээлийн сан		Сая төгрөгөөр	
Шалгагдсан байгууллагын нэр:					
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно гэсэн боловч эргэн төлөх журам байхгүй, тодорхойгүйгээс зээлийн авлага олон жилээр хуримтлагдах, найдваргүй авлага болох эрсдэлтэй, санхүүгийн тайланд хэрэгжихээ зогсоосон хөнгөлөлттэй зээлийн олон жилийн насжилттай авлагын үлдэгдэл байна. Үүнд: Дотоодын их дээд сургуульд хөнгөлөлттэй зээлээр 1995-2003 онд магистрын хөтөлбөрт суралцсан 95 төгсөгчийн 45.0 сая, 2004-2007 онд бакалаврын хөтөлбөрт суралцсан 3,128 төгсөгчийн 3,530.5 сая нийт 3,575.5 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй; Мөн 2008-2020 онд хөнгөлөлттэй зээлээр бакалавр, магистрын хөтөлбөрт суралцсан 11,267 төгсөгчийн 13,168.6 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй ба тайлант онд 162.5 сая төгрөг, өмнөх онд 439.7 сая төгрөг эргэн төлөгдсөн боловч тус зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.		ТЕЗ-д албан шаардлага хүргүүлэх		
2	Тухайн жилд дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутны тоог батлаагүй, гадаад орны дээд боловсролын байгууллагын бакалавр магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа суралцагчдад олгох сургалтын төлбөр, амьжиргааны зардлын зээлийн хэмжээг тогтоогоогүй өмнө оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна		ТЕЗ-д албан шаардлага хүргүүлэх		
3	Өмнөх онуудад гадаадад дээд боловсрол эзэмших суралцагчдад ЗГ-аас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжилд багтаагүй 14 суралцагчийг 2012-2015 онд суралцуулж 1,162.5 сая төгрөг, сонгон шалгаруулалтгүй 11 суралцагчдыг 2017-2018 онд гадаад зээлээр бакалаврын хөтөлбөрт суралцуулж 985.4 сая төгрөг нийт 2,185.0 сая төгрөгийг олгосон байна				
4	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 101 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 47 мэдээлэл, 12.7 сая төгрөгийн зарлагын мэдээллийг оруулаагүй.		Албан шаардлага	БЗС-ийн захирал, Нягтлан бодогч	Ж.Ариунболд, Х.Цэнджав

5	Актлах саналтай ашиглагдахгүй байгаа 42 нэр төрлийн 39.4 сая төгрөгийн компьютер техник хэрэгслийг актлах шийдвэр гаргуулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах 70 нэр төрлийн 114.1 сая төгрөгийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийх шаардлагатай байна.	153.5	Зөвлөмж	БЗС-ийн захирал, Нягтлан бодогч	Ж.Ариунболд, Х.Цэнджав
6	Тайлант онд 32 ААН-тэй хийсэн 61.4 сая төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 6 ААН-үүдээс 4.4 сая төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна	4.4	Зөвлөмж	БЗС-ийн захирал, Нягтлан бодогч	Ж.Ариунболд, Х.Цэнджав
ДҮН		157.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 487/А0160058
САН-2021/10/СТЯ-ЗГТЕ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Боловсролын зээлийн сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 47 мэдээллийг хугацаа хоцроож, 12.7 сая төгрөгийн зарлагын мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж, биелэлтийг 2021 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн захирал Ж.Ариунболд, Нягтлан бодогч Х.Цэнджав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Б.СЭРЖМЯДАГ

ТЭМДЭГЛЭЛ

Lined area with horizontal dotted lines for writing.

